



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Канад улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд “Бодлогын инноваци” бичил төслийг хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд “Бодлогын инноваци 2021”-ийн шалгаруулалтад нийтдээ 21 байгууллага 38 төсөл ирүүлснээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи хамтран дараах 10 төслийг шалгаруулсан байна.

1. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 8-р цэцэрлэгийн Алслагдсан, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох “Хаалга бүрт мэдлэг” төсөл
2. Сангийн яамны Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг олон нийтэд ил тод болгох, оролцогчдыг чадавхижуулах төсөл
3. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгал, халамж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны уялдааг хангах төсөл
4. Авто тээврийн үндэсний төвийн Тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулах “Цахим гэрчилгээ” төсөл
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Дохион хэлийг орчуулах, текстэд хөрвүүлэх шийдлийг тодорхойлох төсөл
6. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутагт аялагчдын ил задгай хог хаях зан үйлийг судлах төсөл
7. Стандарт хэмжил зүйн газрын Үйлчилгээний чанарыг сайжруулах Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх туршилтын төсөл
8. Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсвийг цахимаар нэгтгэх төсөл

9. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын Аргазүйчдийн мэргэжлийн ёс зүй, манлайллын сургалтын хөтөлбөр боловсруулах төсөл

10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчинг

бүрдүүлэх чиглэлээр туршилт хийх, загвар үүсгэх төсөл

Эдгээр төсөлд энэ оны дөрөвдүгээр сараас есдүгээр сарыг дуусталд тус бүр 3000 хүртэлх ам.доллар хүртэлх санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд үр дүнг нь энэ оны аравдугаар сард олон нийтэд танилцуулах аж.